



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/358

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд Хөхморьт, Баян-Уул сумдад зохион байгуулсан явуулын тусламж үйлчилгээ, үзлэг, оношилгоо, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээнд зарцуулах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 29.255.910 (хорин есөн сая хоёр зуун тавин таван мянга есөн зуун арав) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд батлагдсан эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар
сарын 24-ны өдрийн А/358 дугаар
захирамжийн хавсралт

Хөхморьт, Баян-Уул сумдад зохион байгуулсан явуулын эмнэлгийн
үйл ажиллагааны зардлын тооцоо

№	Зардлын үзүүлэлт	Нэгжийн үнэ	Хэмжээ	Нийт зардал
Нэг. Шатахууны зардал				
1.	Улаанбаатарын эмч нар ирж буцах шатахууны зардал /1 машин, 2000км/	3800	424 л	1.611.960
2.	Аймгийн төв-Хөхморьт-Баян-Уул-аймгийн төв /нийт 1900 км, ЭМГ-ын 3 автомашин, явуулын эмнэлгийн үйлчилгээний 4 машин/	2800	380 л	1.064.000
3.	Улаанбаатар хотын эмч нарыг хүргэх унааны зардал /2400км/	3800	432	1.641.600
4.	Улаанбаатар хотоос ирсэн 1 эмчийг Ховд аймагт хүргэх			40.000
Дүн				4.357.560
Хоёр. Албан томилолтын зардал				
5.	Албан томилолт /2 сум*7 хоног*3 хүн/	3	90.000	1.890.000
Дүн				1.890.000
Гурав. Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой зардал				
6.	Шатахуун /түлш/	1017	3600	3.660.000
7.	Шатахуун /АИ-92/	190	2800	532.000
8.	Тос тосолгооны материал	20	16.200	324.000
9.	Машины сэлбэг хэрэгсэл	1	3.417.350	3.417.350
10.	Жолооч нарын цалин	2	2.500.000	5.000.000
11.	Жолоочийн цалингаас байгууллага төлөх НДШ	2	312.500	625.000
12.	Томилолт	15	630.000	9.450.000
Дүн				23.008.350
Нийт дүн				29.255.910